



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/918

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн
авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.6 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дугаар хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн болон улс, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэн нийлүүлсэн, худалдаж авсан нийт 1,174,037,183.60 (нэг тэрбум нэг зуун далан дөрвөн сая гучин долоон мянга нэг зуун наян гурван төгрөг жаран мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан 7 (долоо) тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Тээврийн хэрэгслүүдийг бүртгэн авч, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Нийслэлийн Мал эмнэлгийн газар (М.Түмэннаст)-т, Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв (Д.Шинэбаяр)-д, Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв (Л.Байгал)-д, Багануур дүүргийн Хүүхэд гэр, бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс (Т.Хашлянхуа)-т Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс (Ч.Мөнхбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭН АВАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Д/д	Хөрөнгийн нэр	Марк	Арлын дугаар	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Эх үүсвэр	Эзэмшигч байгууллагын нэр
1	Ариутгалын автомашин	Dongfeng CLW5121GSS 202308	L53P43121PA726623	68-94 УБК	2023	195,000,000.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Нийслэлийн Мал эмнэлгийн газар
2	Суудлын автомашин	Тоёото приус XW 30	ZVW301919488	08-37 УЕН	2015	29,700,000.0	Дүүргийн төсөв	Багануур дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс
3	Бага багтаамжийн автобус	MAN.TGE.180	WMA04VUYXN9018786	41-03 УКО	2023	464,768,591.8	Монгол улсын Засгийн газар Бүгд найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээл	Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв
4	Бага багтаамжийн автобус	MAN.TGE.180	WMA04VUY3N9017706	65-38 УЕУ	2023	464,768,591.8		Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв
5	Мотоцикл	Kayo T2 -ENDURO	KAY0BCNLAR1004116	36-00 УРА	2024	6,600,000.0	Дүүргийн төсөв	Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс
6	Мотоцикл	Kayo T2 -ENDURO	KAY0BCNLAR1004143	36-01 УРА	2024	6,600,000.0	Дүүргийн төсөв	Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс
7	Мотоцикл	Kayo T2 -ENDURO	KAY0BCNLAR1004134	36-02 УРА	2024	6,600,000.0	Дүүргийн төсөв	Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс
Нийт дүн						1,174,037,183.60		